



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар A/103

Улаанбаатар хот

□ Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах □
бичигт тавих шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1425010005

Боловсролын сайдын 2026 оны
06 сарын 03 өдрийн 4/104 дугаар
тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХЭВЛЭМЭЛ СУРАХ БИЧИГТ ТАВИХ ШААРДЛАГА

Энэхүү шаардлагаар бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмших суралцагчдын хэрэглэх хэвлэмэл сурах бичиг (суралцагчийн ном, дасгал ажлын дэвтэр) -т тавих ерөнхий болон тусгай шаардлагыг тогтооно.

Нэг. Ерөнхий шаардлага

Хэвлэмэл сурах бичиг нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

1.1.агуулга нь сургалтын хөтөлбөрт нийцсэн, монгол соёл, үндэсний сэтгэлгээ, өв уламжлал, түүхийн баримт, эх сурвалжид тулгуурласан байх;

1.2.арга зүй нь бодит амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх, мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн, технологийн дэвшлийг харгалзсан, тухайн судлагдахууны суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн шийдэлтэй байх;

1.3.даалгавар нь суралцагчийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, нээлттэй, өдөр тутмын амьдралын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шийдэлтэй, суралцахуйн үр дүн, үнэлгээний зорилго, шалгуур, танин мэдэхүйн үйлийн түвшинтэй уялдсан байх.

Хоёр.Тусгай шаардлага

2.1.Хэл найруулга, зураг дүрслэл, техникийн хувьд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.бичвэрийн өгүүлбэр нь найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй байх;

2.1.2.шинжлэх ухааны болон мэргэжлийн нэр томъёог нэг нэршлээр хэрэглэсэн байх;

2.1.3.таних тэмдэг, нутгийн аялгууны үг, шинэ нэр томъёог ойлгомжтой тайлбарласан байх;

2.1.4.бичвэр бус мэдээллийн дүрслэл, өнгө, дизайн нь бичвэртэй уялдаа холбоотой, харах, унших, ойлгоход хялбар, суралцагчийн анхаарал сарниулах илүү мэдээлэл агуулаагүй байх;

2.1.5.хэвлэлийн эх бэлтгэл болон хэвлэлт нь ISO 12647-2 (Graphic technology Process control for the production of half-tone colour separations, proof and production prints) стандартад нийцсэн байх;

2.1.6.зурмал болон гэрэл зургийн нягтаршил хэвлэлийн эхэд буухдаа 300 PPI-аас багагүй байх;

2.1.7.сурах бичгийн эх бэлтгэл, зураг засалд IPS (In-plane switching) дэлгэц ашиглах;

2.1.8.ухагдахуун, онол, хууль, зарчим, тодорхойлолт, нэр томъёог шинжлэх ухааны хувьд үнэн зөв, алдаагүй, оновчтой томъёолсон байх.

2.2.Хэвлэлийн эх бэлтгэл дараах шаардлага хангасан байна:

2.2.1.Суралцагчийн номын хэмжээ дор дурдсаны дагуу байна.

Анги	Суралцагчийн номын хэмжээ (мм)	Нүүрний хэмжээ (мм)	Нүүрний дөрвөн талын зай (мм)			
			Дээд (мм)	Доод (мм)	Шил (мм)	Задгай (мм)
I-V	203x260	162x216	20	24	22	19
VI-XII	168x240	130x198	20	22	20	18

2.2.2.Дасгал ажлын дэвтрийн хэмжээ дор дурдсаны дагуу байна.

Анги	Дасгал ажлын дэвтрийн хэмжээ (мм)	Нүүрний хэмжээ (мм)	Нүүрний дөрвөн талын зай (мм)			
			Дээд (мм)	Доод (мм)	Шил (мм)	Задгай (мм)
I-XII	205x285	164x241	20	24	22	19

2.2.3.сурах бичгийн сүүлийн нүүрний дугаар нь зохиол, дизайн, эх бэлтгэлийн ажлыг хийж дууссаны дараа 16-д үлдэгдэлгүй хуваагдахаар байх;

2.2.4.сурах бичгийн бичвэрт Юникод фонтыг ашиглах(монгол бичгийн сурах бичигт хамаарахгүй) ба бага ангийн (I-V анги) сурах бичгийн бичвэрт сэртэнгүй (sans serif), дунд, ахлах ангийн сурах бичигт сэртэнтэй (serif) үсгийн фонт хэрэглэх;

2.2.5.бичвэрийн мөр хоорондын зай нь үсгийн фонтын хэмжээний 120 хувиас багагүй; бичвэрийн үг хоорондын зай жигд байх;

2.2.6.үсэг өрөлтийн хэмжээ доор дурдсан хэмжээтэй байна.

Сурах бичиг	Бичвэрийн үсгийн хэмжээ	
	Үндсэн	Бүдүүвч, график, зургийн тайлбар, хүснэгт
I анги	14, 16, 18, 20, 24, 28	10, 12
II-V анги	12, 14	10, 11
VI-VIII анги	11	9, 10
IX-XII анги	11	9, 10

2.2.7.сурах бичгийн томьёо, тусгай тэмдэгтийн үсгийн фонт болон хэмжээ нь үндсэн бичвэрийн үсгийн фонттой ижил байх бөгөөд доор дурдсан хэмжээтэй байна.

Тусгай тэмдэгт	Ерөнхий нэршил	Хэрэглээ	Тэмдэгтийн код	Жишээ
-	зураас	нийтлэг	45	Баян-Өндөр, 45 оС-ээс
—		хасах тэмдэг харилцан яриа	0150	315 – 45 – Сайн байна уу?
—		тусгай (физик, хими)	0151	H2O — CL2
+	нэмэх	нэмэх тэмдэг	002B	315 + 45
÷	хуваах	хуваах тэмдэг	00F7	115 ÷ 5
×	үржүүлэх	үржүүлэх тэмдэг	00D7	15 × 5

2.2.8.Сурах бичигт хэрэглэх зарим нэгж, тэмдэгтүүдийг доор дурдсаны дагуу бичнэ.

Тусгай тэмдэгт	Бичигдэх хэлбэр	Жишээ
тоо	босоо	15, 24
нэгж	босоо	кг, л, м
харьцааны болон үйлдлийн тэмдэг	босоо	+, −, ÷, ×, <, >, =,
хувьсагч	налуу (<i>italic</i>)	12 <i>y</i> , 24 <i>b</i>
тооны ард бичигдэх нэгж	тооны араас статик дунд зай (static em space) авч нэгжийг бичнэ	1 кг

2.3.Сурах бичгийн хэвлэн нийтлэлийн хуудсанд доор дурдсан үндсэн мэдээллүүдийг оруулсан байна.

2.3.1.нэр, дэд гарчиг (анги, судлагдахуун, зориулалт)

2.3.2.дагалдах номтой бол нэр, холбогдох мэдээлэл (суралцагчийн ном, дасгал ажлын дэвтэр, багшийн ном, электрон хувилбар)

2.3.3.анхны хэвлэлтийн огноо

2.3.4.дахин хэвлэлтийн дугаар, огноо

2.3.5.нөхөн хэвлэлтийн дугаар, огноо

2.3.6.олон улсын стандарт дугаар (ISBN)

2.3.7.номын сан, ном зүйн ангиллын заалт (HNA, ДАА, УДК)

2.3.8.хэвлэх зөвшөөрөл, итгэмжлэлийн мэдээлэл

2.3.9.Зохиогчийн эрхийн мэдээлэл

2.3.9.1.Зохиогчийн эрх эзэмшигчийн мэдээлэл, таних тэмдэг

2.3.9.2.Мэдэгдэл

2.3.10.Хэвлэн нийтлэгчийн мэдээлэл

2.3.10.1.Хэвлэн нийтлэгчийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл

2.3.10.2.Зохиогчийн багт ажилласан зохиогч, редактор, зөвлөх, эх бэлтгэгч, зураач болон бусад бүх оролцогчийн нэр, гүйцэтгэсэн үүрэг тус бүрдээ цагаан толгойн үсгийн дарааллаар бичигдсэн байх

2.3.11.Хэвлэх үйлдвэрийн мэдээлэл

2.3.11.1.хэвлэх үйлдвэрийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл

2.3.11.2.олон улсын чанарын ISO 14001 стандартыг хэрэгжүүлэгч тэмдэг

2.4.Хэвлэх үйл явц нь дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1.Сурах бичгийг олон улсын чанарын ISO 14001 стандартыг хэрэгжүүлэгч үйлдвэрт хэвлэх;

2.4.2.цаас нь химийн цайруулалт хийгдээгүй, модны хольцгүй, 70-80 хувийн цайралттай, 93-100 микрон зузаантай, 79-81 г/м² -ын жинтэй оффсет гөлгөр шаргал (Ivory) байх;

2.4.3.цаас нь химийн цайруулалт хийгдээгүй, модны хольцгүй, 100-120 хувь цайралттай, 93-100 микрон зузаантай, 79-81 г/м²-ын жинтэй оффсет цагаан байх;

2.4.4.сурах бичгийн хавтасны цаас нь 90-100 хувийн цайралттай, 210-230 г/м²-ын жинтэй, 250-280 микрон зузаантай, нэг тал шохойтой байх;

2.4.5.сурах бичгийн хавтсыг бүрсэн байх;

2.4.6.сурах бичгийн хэвлэлтийн растер цэгийн нягтаршил 250-300 DPI (175-200 LPI) байх;

2.4.7.сурах бичгийн хуудасны ар, өврийн хэвлэлтийн зөрүү 0.5 мм-ээс ихгүй байх;

2.4.8. 80 хүртэлх нүүртэй сурах бичгийг шулуун оёдлоор оёж, хоёр үдээсээр үдэж бэхлэх;

2.4.9. 80 хүртэлх нүүртэй дасгал ажлын дэвтрийг хоёр үдээсээр бэхлэх;

2.4.10. 80-аас дээш нүүртэй сурах бичгийг 16-32 нүүрээр оёж, халуун цавуугаар наах эсвэл түүнтэй дүйцэх технологиор бэхлэх;

2.4.11.халуун цавуун бэхэлгээтэй сурах бичгийн хавтас нь шилний ирмэгээс 6-8 мм горвитой байх;

2.4.12.номыг гурван талаас огтолсон хэмжээний алдаа нь ± 1 мм-ээс ихгүй байх.

---oOo---